



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 514

Улаанбаатар хот

“Мерекс” ХХК-ийн нийтэд санал болгон  
гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 23, 42 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 4.25 дахь заалт, “Мерекс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2013 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мерекс” ХХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан уг компанийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 65,005,000 /жаран таван сая таван мянга/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Иргэн Д.Батцэцэгийн эзэмшилд “Мерекс” ХК-ийн 31,204,000 /гучин нэгэн сая хоёр зуун дөрвөн мянга/ ширхэг хувьцааг, иргэн М.Ундралын эзэмшилд “Мерекс” ХК-ийн 7,801,000 /долоон сая найман зуун нэг мянга/ ширхэг хувьцааг тус тус хөрвүүлсэн тул эдгээр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 2-т заасан хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд хөрвүүлэн бүртгэсэн хувьцаанаас бусад нийт 26,000,000 /хорин зургаан сая/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 100 /нэг зуу/ төгрөгөөр тогтоон нийтэд анх удаа санал болгон худалдахыг зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын 2-т заасан нэр бүхий хувь нийлүүлэгчдийн хувьцааг өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэсэн өдрөөс эхлэн бетон зуурмагийн үйлдвэрийн төсөл бүрэн хэргэжиж, эдийн засгийн үр өгөөжөө өгч эхлэх хүртэлх хугацаанд тусгаарлах арга хэмжээ авах, тэдгээрийн өмчлөлийн үнэт цаасанд үүрэг хүлээсэн барьцааны гэрээг бүртгэхгүй байх, Хорооны хуралдаанаар “Мерекс” ХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн энэхүү төслийн хэрэгжилт, эдийн засгийн үр ашгийн тооцоог хэлэлцэн, тогтоолоор олгосон зөвшөөрлийн үндсэн дээр тусгаарлалтаас чөлөөлөхөөр тогтсугай.

5. Хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад нь шаардлагатай хууль тогтоомжид заасан мэдээллийг хүргэж, Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх, төлбөр тооцоо, бүртгэлийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг “Мерекс” ХХК /М.Мөнхзолбоо/, “Стандарт инвестмент” ХХК /Ч.Жаргал/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

6. Нийт гаргах энгийн хувьцааны 70 хувь буюу 18,200,000 ширхэгээс доошгүй арилжигдсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

7. Энэхүү тогтоолын 6-д заасны дагуу Хорооноос үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж дүгнэх хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг “ҮЦТТГХТ” ХХК-д байрших тусгай дансанд тусгаарлахыг “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

8. “Мерекс” ХХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр хоёрдогч зах зээлийн арилжааг нээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

9. “Мерекс” ХХК-ийн нийтэд санал болгон худалдсан үнэт цаасыг худалдан авсан хувьцаа эзэмшигчдийн тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхийг хангах зорилгоор Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.5 дахь заалт нь тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахад үйлчлэхгүй болохыг тогтоож, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах “бүртгэлийн өдөр”-ийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрийн өмнөх өдөр байхаар тогтоосугай.

10. Тус компанийн шинээр үнэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Мерекс” ХХК /М.Мөнхзолбоо/, “Стандарт инвестмент” ХХК /Ч.Жаргал/-д тус тус үүрэг болгосугай.

1/ энэхүү тогтоолын 3-т заасан нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 26,000,000 ширхэг хувьцааг гаргах тухай үнэт цаасны товч ба дэлгэрэнгүй танилцуулгыг Үнэт цаасны газраар баталгаажуулан, уг үнэт цаасны танилцуулгад үндэслэн холбогдох журмын дагуу үнэт цаасыг нийтэд сурталчлан, олон нийтийг бодитой мэдээллээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа хийгдэж дууссанаас хойш холбогдох журмын дагуу 10 хоногийн дотор үнэт цаасны гүйлгээний талаарх дэлгэрэнгүй тайланг Хороонд ирүүлэх;

3/ үнэт цаасны танилцуулгад заасны дагуу үнэт цаасыг нийтэд санал болгох ажлыг зохион байгуулж, арилжаалагдаагүй үлдсэн хувьцааны талаар холбогдох шийдвэр гаргуулахаар Хороонд хандаж шийдвэрлүүлэх;

4/ үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн


нэгдсэн сангийн тухай журам"-д заасан мэдээллийг цаг тухайд нь ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах.

5/ "Монголын компанийн засаглалын кодекс"-т нийцүүлэн ажиллах.

11. "Мерекс" ХХК нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болж буйгаа Улсын бүртгэлийн албанд энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш 10 хоногийн дотор бүртгүүлж, Хороонд мэдэгдэхийг "Мерекс" ХХК /М.Мөнхзолбоо/-д даалгасугай.

12. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН